

Төгсөгчийн сэтгэгдэл

Г.Гүнбилэг

- Сайтамагийн Их Сургууль
- Нийгэм, Хүмүүнлэгийн
- Шинжлэх Ухааны Их Сургууль
- Магистр : JDS 2019-2021



Миний хувьд Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгждэг Японы Хөгжлийн Тэтгэлэг (ЯХТ) -ээр эдийн засгийн ухааны мастерын зэргийг 2021 онд Сайтамагийн Их Сургууль (СИС) -д хамгааллаа. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөр нь Япон улсаас Монгол улсын хүний нөөцийн хөгжлийн төлөө оруулж буй маш том хөрөнгө оруулалт билээ. ЯХТ нь тэтгэлэгт хамрагдагчийг орон байр, амьжиргааны зардал, эрүүл мэндийн даатгал, унааны зардал, гэр бүлтэйгээ хамт амьдрах дэмжлэг гээд бүх талаар туслан дэмжихээс гадна, улирал бүр мониторингийн үүлзалт хийж эрүүл мэнд, сургалт, судалгаанд тулгарч буй хүндрэл бэрхшээл болон ахиц дэвшлийн талаар ярилцдаг болохоор 2 жилийн хугацаанд зөвхөн хичээл сургалтандаа анхаарах боломжтой.


СИС-д суралцсанаар бодлого боловсруулалт, эдийн засаг, статистикийн судалгааны аргуудыг нарийвчлан судалж, олон улсын сэтгүүлүүдэд хүлээн зөвшөөрөгдөх эрдэм шинжилгээний ажлуудыг боловсруулах арга зүй, чадамжийг эзэмшсэн бөгөөд ийм мундаг сургуульд суралцаж, чадварлаг багш нартай хамтран судалгаа хийх боломж олгосон ЯХТ –д тун их талархаж байна. Сайтамагийн их сургуулийн профессоруудын хувьд Англи, Австрали зэрэг улсын шилдэг их сургуулиудад докторын зэргээ хамгаалснаас гадна Японы Сангийн Яам, Төв банк, Жайка зэрэг төрийн байгууллагад ажиллаж байсан түршлагатай болохоор бодит практикаар онолын мэдлэгийг тань баяжуулах болно.

Иймд энэ хөтөлбөрт та бүхэн хамрагдаж Монгол Улсынхаа хөгжлийн төлөө хувь нэмэрээ оруулж байхыг чин сэтгэлээсээ хүсэж байна.

Хөтөлбөрийн тойм

“Хүний Нөөцийг Хөгжүүлэх JDS Тэтгэлэгт Хөтөлбөр” нь Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй урт хугацааны хөтөлбөр юм. Тус хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчдыг Япон улсын их дээд сургуулиудын магистрантурт (2 жил)/ докторантурт (3 жил) англи хэл дээр суралцуулах замаар Монгол улсын хүний нөөцийн хөгжлийг дэмжиж, Монгол Японы найрамдалт харилцааг бэхжүүлэхэд оршино. Ирээдүйд эх орондоо удирдах албан тушаал хаших 15 залуу төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулахаар 2021 оны элсэлтээ зарлаж байна. (2022 оны 9-10 сард сургуульдаа элсэнэ.)

Мэдээлэл авах хаяг



Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Төв JICE JDS Төслийн Монгол дахь Оффис

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж, Монгол-Япон Төвийн байр, 201 тоот

Утас: 976-11-327052, 976-11-326815

Цахим шуудан: jds.mongolia@jice.org

Facebook хаяг: @JDSMongolia

Ажлын цаг: Даваа-Баасан 9:00 - 12:30, 14:00 - 17:30



Япон улсын магистрантурт суралцах тэтгэлэгт хөтөлбөр

Япон Улсын Засгийн Газрын Буцалтгүй Тусламж “Хүний Нөөцийг Хөгжүүлэх (JDS) Тэтгэлэгт Хөтөлбөр” Монгол улс 2021



Суралцах чиглэл болон хүлээн авах их сургуулиуд

JDS оюутан нь Монгол орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болон хөгжлийн асуудлуудыг шийдэхэд чиглэгдсэн дараах дэд хөтөлбөр болон бүрэлдэхүүн хэсгийн аль нэгийг сонгон суралцана.

*Бүрэлдэхүүн хэсэг 2-1 хувьд 2 сургуульд зэрэг өргөдөл гаргах боломжтой (Олон улсын их сургууль болон Хирошимагийн их сургууль).

Дэд Хөтөлбөр (Тэргүүлэх чиглэл)	Бүрэлдэхүүн хэсэг (Хөгжлийн Асуудал)		Хүлээн авах Их сургууль Хүлээн авах тэнхим	Хүлээн авах тоо
1. Макро эдийн засгийн эрүүл үйл ажиллагаа ба засаглалыг бэхжүүлэх	1-1 Төрийн санхүүгийн удирдлагын чадавхийг сайжруулах	1-1-1 Төрийн санхүүгийн удирдлага	Сайтамагийн их сургууль Хүмүүнлэг, нийгмийн ухаан судлалын тэнхим	2
		1-1-2 Төрийн захиргаа	Мэйжигийн их сургууль Засаглал судлалын тэнхим	2
	1-2 Эрчимтэй зах зээлийн эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэг	1-2-1 Санхүүгийн бодлого, хөрөнгийн зах зээлийн бодлого	Олон улсын их сургууль Олон улсын харилцааны тэнхим	2
		1-2-2 Бизнес, эдийн засгийн эрх зүйн тогтолцоо	Кюүшүгийн их сургууль Хуулийн тэнхим	1
2. Хүрээлэн буй орчинтой зохицсон эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангах	2-1 Аж үйлдвэрийн бодлого ба бизнесийн удирдлага		Олон улсын их сургууль Олон улсын менежментийн тэнхим	2
			Хирошимагийн их сургууль Ахисан түвшний шинжлэх ухаан болон инженерчлэлийн тэнхим	2
	2-2 Өсөлтийг хангахуйц өндөр чанартай дэд бүтцийг байгуулах		Нагаока технологийн их сургууль Иргэний барилга, байгаль орчны инженерчлэлийн тэнхим	2
	2-3 Хотын хүрээлэн буй орчны менежментийг сайжруулах		Цүкүбагийн их сургууль Шинжлэх ухаан, технологи судлалын тэнхим	2

Тавигдах шаардлага

- Монгол улсын иргэн байх
- 2022.04.01-ний байдлаар 25-39 настай байх
- Баклаврын зэрэгтэй байх
- Өргөдлийн маягт хүлээж авах эцсийн өдрийн байдлаар одоо ажиллаж буй байгууллагадаа үндсэн албан хаагчаар 2-оос дээш жил ажилласан байх:
 - Төрийн жинхэнэ албан хаагч (Төрийн захиргааны <ТЗ> болон Төрийн тусгай <ТТ>)
 - Монгол банк болон Монголын хөгжлийн банкны ажилтан байх.
- Гадаад орны тэтгэлгээр магистр болон түүнээс дээш зэрэг горилоогүй байх
- Цэргийн албанд харьяалалгүй байх
- Бие махбодь, сэтгэцийн хувьд эрүүл байх
- TOEFL iBT 60 (ITP 500) / IELTS 5.5-аас дээш оноотой байвал давуу талтай

Тэтгэлгийн агуулга

JDS-н тэтгэлэгт доорх зүйлс хамрагдана.

- 1-р сонгон шалгаруулалтад тэнцсэн элсэгчдэд зориулсан 50 цагийн англи хэлний сургалт
- Эцсийн байдлаар тэнцсэн оюутнуудад зориулсан 100 цагийн япон хэлний сургалт
- Япон дахь их сургуулийн сургалтын төлбөр
- Хоёр талын онгоцны зардал
- Японд амьдрах амьжиргааны зардал (сар бүр)
- Байрны мөнгө
- Тээврийн зардал
- Бусад зардал (Ном сурах бичиг, Тээвэрлэлтийн зардал, Семинар, Эрүүл мэндийн даатгал, гэх мэт.)



Хэрхэн бүртгүүлэх вэ

- Элсэлтийн удирдамжийг JDS хөтөлбөрийн албан ёсны цахим хуудаснаас татаж авна уу. <http://jds-scholarship.org>
- Өргөдлийн маягтыг онлайнаар бөглөж холбогдох бичиг баримтыг онлайн платформд оруулан доорх хугацаанаас өмнө бүртгүүлнэ үү.



2021 оны 10-р сарын 27 (14:00)

Сонгон шалгаруулалтын хуваарь

Бүртгэл онлайнаар явагдана

Англи хэл / Математикийн шалгалт

< 2021 оны 11 сар >
TOEFL (ITP) болон математикийн шалгалтыг материал бүрэн бүрдүүлсэн элсэгчдээс авна

1-р сонгон шалгаруулалт

< 2021 оны 12 сар >
Хүлээн авах их сургуулийн профессорууд материалын сонгон шалгаруулалтыг хийнэ

Англи хэлний сургалт

Англи хэлний сургалтанд 1-р сонгон шалгаруулалтад тэнцсэн элсэгч хамрагдана

2-р сонгон шалгаруулалт

< 2022 оны 2-3 сар >
Хүлээн авах их сургуулийн профессорууд Улаанбаатар хотод мэргэжлийн ярилцлага авна

3-р сонгон шалгаруулалт

< 2022 оны 3 сарын сүүлээр >
JDS хөтөлбөрийн Удирдах зөвлөл Улаанбаатар хотод ярилцлага авна.

JDS-н оюутанд олгогдох тэтгэлэг

Доорх төлбөр болон бусад бүх элсэлттэй холбоотой зардал JDS хөтөлбөрөөс гарна:

- TOEFL ITP шалгалт болон эрүүл мэндийн үзлэгийн төлбөр
- Улаанбаатар хотод ярилцлаганд орох үеийн тодорхой хэмжээний тээврийн зардал